



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A105

Улаанбаатар хот

Салбарын албан хаагчдын ёс  
зүйн үлгэрчилсэн загварыг  
батлах ба түүний мөрөөр зохиох  
ажлын тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1."Салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн үлгэрчилсэн загвар"-ыг тушаалын хавсралт ёсоор баталсугай.

2."Салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн үлгэрчилсэн загвар"-ын дагуу ёс зүйн холбогдох дүрэмд зохих нэмэлт, өөрчлөлт оруулахыг харьяа агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3."Салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн үлгэрчилсэн загвар"-ыг албан хаагчдад сурталчилан таниулах арга хэмжээ авахыг харьяа агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Салбарын албан хаагчийн ёс зүйн суурь сургалтыг нийслэл болон орон нутагт зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/, Төрийн захиргааны удирдлагын газар /П.Хадбаатар/, харьяа агентлаг, байгууллагын дарга нарт, холбогдох зардал гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Л.Хосбаяр/-т даалгасугай.

5. Ёс зүйн зөвлөлөөс албан хаагчийн талаар гаргасан ёс зүйн дүгнэлт болон алба хаагчийн ёс зүйн сайн туршлага, бусдад бодит үлгэр дууриалал болохуйц жишээ баримтыг байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан тогтмол мэдээлж байхыг харьяа агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзоригт даалгасугай.



Х.НЯМБААТАР

151600362

2022.05.10,  
дугаар 29



ХАРЬЯА АГЕНТСТВО  
БАИГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Заспийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-майл: foreign@mojna.gov.mn,  
Вебсайт: www.mojna.gov.mn

2022.05.02 № 412510  
тагай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тушаал хүргүүлэх тухай

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/105 дугаар "Салбарын албан хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн загварыг батлах ба түүний мөрөөр зохиох ажлын тухай" тушаалыг хүргүүлж байна.

Тушаалтай танилцан өөрийн байгууллагын ёс зүйн дүрэм, журамд тохирх өөрчлөлтийг оруулан, сургалт зохион байгуулах хуваарийг гарган 2022 оны 05 дугаар сарын 13-ны дотор ирүүлнэ уу.

Байгууллагаас ирүүлсэн хуваарийн саналыг харгалзан сургалт зохион байгуулагдах болно.

Хавсралт ... хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА



П.ХАДБААТАР

Хууль зүй, дотоод хэргийн  
сайдын 2022 оны 11. сарын  
29.-ны өдрийн АНДС.. дугаар  
тушаалын хавсралт

## САЛБАРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН

### ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

1. Төрийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа хууль тогтоомжоор итгэж хүлээлгэсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэнтэй эелдэг, хүлээцтэй, тэвчээртэй. ажил хэрэгч, зарчимч, даруу төлөв харьцааж байх ёстай. Иргэнтэй будуулэг, хүйтэн цэвдэг, дээрэнгүй, балмад, согтуу хөлчүү харьцах, түүнийг айлан сурдуулэх, дарамтлах, хясан боогдуулах, эрхшээлдээ оруулах, хувийн харьцаа тогтоох, басамжлан доромжлох нь төрийн алба хаагчийн нэр төрийг шууд унагаж гутаасан зан үйл болно. Төрийн алба хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нэр төрийг хүндэтгэж, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хангах ба хамгаалах ёстай.

2. Төрийн алба хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа хэнийг ч үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, гарал, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхах ёсгүй бөгөөд иргэнтэй шударга, тэгш харьцааж байгаагаа хөндлөнгийн хэнд ч ойлгогдох байдлаар илэрхийлж байх ёстай. Төрийн алба хаагч нь хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцахдаа төвийг сахисан байдлыг хангаж, хувийн итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэхээс зайлсхийх ёстай.

3. Төрийн алба хаагч нь шударга зан үйлийг эрхэмлэн баримтлах учиртай. Хүлцэж болохуйц алдаа дутагдал байдаг ч хэрэв төрийн алба хаагч шударга бус зан үйл гаргавал иргэд яагаад ч училж үздэггүй, шударга бус явдлыг тэвчдэггүй гэдгийг цаг ямагт онцгой анхаарах ёстай. Голч шударга байдлыг төрийн алба хаагчийн ёс зүйн хамгийн нандин чанар хэмээн үзвэл зохино. Төрийн алба хаагч нь хувийн болон нийгмийн амьдралдаа нэр төртэй, үнэнч, зарчимч, хүндлэл төрүүлэхүйц байдлыг эрхэмлэх ёстай.

4. Төрийн алба хаагч нь хахууль авах ёсгүй. Хахууль нь шударга ёс болон ёс суртахууны нандин чанарыг хөсөрдүүлж, төрийн нэр хүндийг олон түмний дунд гутаадаг учрыг сайтар ухамсарлах ёстай. Төрийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулан хувь хүн болон хуулийн этгээдээс шагнал (бэлэг, мөнгөн шагнал, зээл, үйлчилгээ, зугаа цэнгэлийн ба амралтын төлбөр, тээврийн хэрэгслийн зардал болон бусад шагнал) авахыг эрс хатуу цээрлэнэ. Төрийн алба хаагч нь хувиараа болон итгэмжлэгдсэн этгээдээрээ дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх ёсгүй.

5. Төрийн алба хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ хариуцлагатай, сахилга баттай ажиллах ёстай. Аливаа шийдвэр гаргахдаа асуудал (гомдол, өргөдөл, хүсэлт зэрэг), хэрэг, маргааны үйл баримт, хэрэглэх хууль тогтоомжийт бүхий л талаас нь нухацтай дүгнэн шинжилж, аливаа эргэлзээ тээнэгзлэлгүй болтол нь тунгаан лавшруулж шалгасан бодит дүгнэлтэд үндэслэх ёстай. Төрийн алба хаагч нь хэрэг, маргаан, асуудлын талаар сэжиг таамагт үндэслэн урьдчилан дүгнэлт хийж, түүнийгээ батлахын тулд улайран хөөцөлдөж, нэг талыг баримтлах ёсгүй. Өөрт мэдээжийн санагдсан таамаг буюу эсхүл шийдлийг шүүрэн авч хэрэглэх замаар хөнгөн гоомой хандах ёсгүй бөгөөд тухайн асуудлыг байнга лавшруулан нягталж, эргэж магадалсан байх ёстай. Хуулиар тогтоосон бүрэн эрхээ нарийн нягт, няхуур, нухацтай, өндөр шаардлага тавьж, өөртөө хяналт тавьж хэрэгжүүлэх нь аливаа алдаа эндэгдэл гаргахаас төрийн алба хаагчийг сэрэмжлүүлнэ. Удирдах албан тушаалтан ёс зүйн хувьд бусдад үлгэр дууриалал үзүүлж байх ёстай.

6. Төрийн алба хаагч нь албаны үүргээ хэрэгжүүлэхдээ итгэл дааж ажиллах ёстай. Голч шударга, үнэнч, чармайлттай, туйлбартай, хүнийг сонсож чаддаг, тэсвэр тэвчээртэй, худал амладагтүй, хуурч мэхэлдэгтүй, хоёр нүүрлэдэгтүй чанараа хөсөрдүүлбэл итгэл даахгүй гэдгийг байнга санаж ажиллах ёстай. Хууль зүй, дотоод хэргийн салбарын нэр хүнд алба хаагч нэг бүрийн нэр төрөөс шууд шалтгаална.

7. Төрийн алба хаагч нь төрийн байгууллагад тогтоосон хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг чанд сахин биелүүлж, албаны бус зорилгоор материал-техникийн, санхүүгийн хэрэгсэл, төрийн бусад эд хөрөнгө, албаны мэдээллийг ашиглах ёсгүй. Төрийн алба хаагч нь төрийн болон хуулиар хамгаалагдсан бусад нууцыг хадгалж, албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан иргэний хувийн амьдрал, нэр төрийг хөндсөн мэдээ сэлтийг задруулахгүй байх ёстай.

8. Төрийн алба хаагч нь хууль тогтоомжоор ногдуулсан албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх, хэрэг болон асуудлыг чирэгдэлгүй, сунжуулахгүй шийдвэрлэхэд нэн шаардлагатай мэдлэг, мэргэжлийн ур чадварыг эзэмших талаар байнгын хичээл зүтгэл гарган, чармайлттай ажиллах ёстай.

Э.Хууль зүй, дотоод хэргийн салбарын төрийн тусгай алба хаагч нь олгогдсон эрхийг хуульд нийцүүлэн ашиглах бөгөөд үйл ажиллагааныхаа явцад иргэн ба аж ахуйн нэгжийн эрх ба хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх ёсгүй. Төрийн тусгай алба хаагч нь цагдан хорих, барьцаа авах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх, баривчлах зэрэг шийтгэлийг ногдуулахдаа хуульд заасан үндэслэл тухайн тохиолдолд бодитой, баримттай байгаа зсэхийг нухацтай авч үзэж, лавшуулан шалгаж, алдаа гаргахаас байнга сээрэмжлэх ёстай. Төрийн тусгай алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхийг урьдал болголгүй гагцхүү тэдгээрийг албаны үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй онцгой тохиолдолд шаардагдах хэр хэмжээнд тохицуулан ашиглах ёстай.

10. Төрийн тусгай алба хаагч (цагдаагийн алба хаагч) нь гэмт хэрэг, зерчил золгуй тохиолдлоос хохирсон болон биез хамгаалж чадахгүй еер бусад байдлаар амь нас нь аюултай байдалд байгаа иргэнд хүнлэг энэрэнгүй хандаж, юуны өмнө эмчийн өмнөх тусламж үзүүлэх ёстай. Төрийн тусгай алба хаагч нь saatуулагдсан хүмүүсийн эруул мэндийг бүрэн хамгаалах, тухайлбал, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх яаралтай арга хэмжээ авах ёстай. Төрийн тусгай алба хаагч (мөрдөгч) нь аливаа иргэний шударгаар олж авсан хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийг хууль бусаар битүүмжлэх ба хураан авахыг эрс цээрпэж, хэрэгт холбогдон шалгуулагчийн гэр булийн гишүүдийн хэвийн амьдралд хайр найргүй, хүнлэг бус хандахаас байнга сээрэмжлэх ёстай. Төрийн тусгай алба хаагч эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах аливаа үйлдлийг хийх, өдөөн турхирах болон эвлэрэнгүй хандах ёсгүй.



